

Унэт цаасны хорооны 1996 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт

## ДАНСНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ ХӨТЛӨХ, ХАДГАЛАХ ЗААВАР

Бүртгэлийг № А9-1 маягтаар гаргана. Бүртгэл нь: дугаар, таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр, танд ямар хамааралтай болох, брокерын пүүсийн дансны дугаар, паспортын дугаар, регистр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, тэмдэглэл гэсэн хэсэгтэй байна.

Үнэт цаасны хорооны дарга, гишүүн, ажилтнууд, Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга, гишүүн, захирал, ажилтнууд, Үнэт цаасны компанийн удирдах ажилтан бүртгэлийг өөрөө гаргана.

Бүртгэл нь нууцын зэрэглэлтэй байна.

Хорооны гишүүд, албаны мэргэжилтний бүртгэлийг Үнэт цаасны хороонд, Биржийн болон үнэт цаасны компанийн удирдах ажилтны бүртгэлийг МХБ-д ирүүлж тус тусдаа хадгалж хамгаална.

Хувьцаат компанийн удирдлага, багц хувьцаа эзэмшигчид бүртгэлийг уг байгууллагын удирдлагад ирүүлж хадгалж хамгаална.

Маягтын асуулгад дараах байдлаар хариулж бичнэ.

1/ Маягтын "Таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр" гэсэн асуулгад:

а/ Эхлээд таны болон эхнэр, нөхрийн төрөл төрөгсдөөс /аав, ээж, ах, эгч, дүү, хүүхэд,/ брокерын пүүст данс нээлгэсэн хүмүүсийн нэрс;

б/ Дараа нь таны төрөл төрөгсдөөс брокерын пүүст данс нээлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалд болон аль нэг хувьцаат компанийн нийт хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг бол уг байгууллагын оноосон нэр;

в/ Эцэст нь таны төрөл төрөгсдөөс үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд ажилладаг бол оролцогч этгээдийн оноосон нэр.

2/ Маягтын "Таны юу болох" гэсэн асуулгад хамаарлуудыг бичнэ. Жишээ нь: "Миний эцэг, дүү, тийм компанийн захирал, ТУЗ-ийн гишүүн, тийм компанийн гэдэн хувийг эзэмшигч" гэж хариулна.

3/ "Брокерын пүүсийн дансны дугаар" хэсэгт тухайн этгээдийн дансны дугаар бичнэ.

4/ Хамааралтай этгээд хувь хүн бол "паспортын дугаар, регистр" гэсэн хэсгийг, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан бол тухайн байгууллагын "улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар" гэсэн хэсгийг хариулна.

5/ Маягтын асуулгын "Тэмдэглэл" гэсэн хэсэгт уг этгээдийн эзэмшиж байгаа үнэт цаас /код-тоо ширхэг/, мөнгөн хөрөнгө, тухайн үнэт цаасны эзлэх хувь, хэзэв 5 хувиас дээш бол давсан үеийн огноо, дансанд хийгдсэн хөдөлгөөн зэргийг бичнэ.

Бүртгэл гаргагч болон бүртгэл хүлээн авагч албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

Эзэмшиж байгаа үнэт цааст хөдөлгөөн орсон тохиолдол бүрт үнэт цаас



Нууц

Үнэт цаасны хорооны 1996 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт  
Маягт № А9-1

**Дотоод мэдээлэл эзэмшигч болон түүнд хамааралтай  
этгээдийн дансны бүртгэл**

Дотоод мэдээлэл эзэмшигчийн овог нэр .....  
албан тушаал.....  
кодны дугаар .....

№	Таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр	Таны юу болох	Брокерын пүүсийн дансны дугаар	Паспор- тын дугаар, регистр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Тэмдэглэл

1. Үнэт цаасны тухай Монгол улсын хуулийн 21, 22 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
2. Дансны дугаарт өөрчлөлт орсон, нэмэгдсэн тохиолдолд та маягтыг дахин бичнэ.
3. Энэхүү бүртгэлийг хүлээн авсан алба, ажилтан нууцыг хамгаалах үүргийг хуулийн өмнө хүлээнэ.

Асуултад үнэн зөв хариулсан:

ҮЦХ, МХБ, Үнэт цаасны компани, хувьцаат /доогуур зур/  
компанийн ..... /албан тушаалтан/

ГАРЫН ҮСЭГ ..... /

Хүлээн авсан хүний

ГАРЫН ҮСЭГ...../  
Албан тушаалтан.....

199.. оны ... сарын ... -ний өдөр

Үнэт цаасны хорооны 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 114 дүгээр тогтоолын хавсралт

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ**

Сүүлчийн 52 долоо хоногийн ханш	Хувьцааны нэр		Ангилал	нэгж хувьцаа			Арилжаалагдсан ширхэг	1996.12.26-ний өдрийн ханш				Ханшийн өөрчлөлт	
	Дээд	Доод		Ногдол ашиг	Ногдол ашгийн өгөөж	Цэвэр ашгийн өгөөж		Дээд	Доод	Хаалт	Дундаж*		
570	58	АПУ	A	85	16.67	364.33	...	560	505	510	-25		
1900	20	Монгол	B	...	...	54.96	762	1500	510	800	50		
100	50	Эрэлмаш	C	...	...	...	...	...	...	...	...		

Тайлбар

Сүүлчийн 52 долоо хоногийн арилжааны хамгийн дээд доод ханш, МХБ-ийн бүртгэлд орсон хувьцаат компанийн нэр, МХБ-д бүртгэлтэй үнэт цаасыг "МХБ-д үнэт цаас бүртгэн авах тухай" журмын дагуу А, В, С гэсэн 3 ангилалд хуваасан байдал. Бүртгэн авах тухай" журмын дагуу А, В, С гэсэн 3 ангилалд хуваасан байдал. Найдвартай, эрсдэл багатай дээд ангиллын үнэт цаас Зохих шалгуур хангасан дунд ангиллын үнэт цаас, Найдваргүй, эрсдэл өндөөтэй доод ангиллын үнэт цаас Тухайн компанийн сүүлчийн нэг жилд нэгж хувьцаанд олгосон ногдоол ашгийн хэмжээ Ногдол ашгийн хэмжээг тухайн арилжааны өдрийн хаалтын харьцуулан тодорхойлсон нэгж хувьцааны ногдол ашгийн өгөөж Компанийн тайлант жилийн татавар хассаны дараах цэвэр ордогыг компанийн нийт гаргасан хувьцааны тоонд хувааж гаргасан нэгж хувьцааны цэвэр ашгийн өгөөж. Тухайн өдөр арилжаалсан хувьцааны тоо, ширхэг, Арилжааны тухайн өдрийн ханш Ханшийн өөрчлөлт /төгрөгөөр/

\* Үнэт цаасны хорооны 1997 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолор нэмсэн